

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРААС  
2018 ОНЫ 09 ДҮГЭЭР САРД ХЭРЭГЖҮҮЛСЭН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**


2018 оны 10 дугаар сарын 01

Улаанбаатар хот

Тус газар нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Харьяатын тухай хууль болон тэдгээрт нийцүүлэн гаргасан бусад дүрэм, журам, зааврыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон гадаадын болон өөрийн орны иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчлэхэд анхаарч 2018 оны 08 дугаар сарын 26-ны өдрөөс 09 дүгээр сарын 25-ны өдрийн хугацаанд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

**НЭГ. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР**

**1.1 Виз, зөвшөөрлийн чиглэлээр:**



Тайлангийн хугацаанд “Монгол Улсад оршин суух үнэмлэх” 3203 ширхгийг шинээр хэвлэн, 1280 ширхэг үнэмлэхийн хүчинтэй хугацааг сунгаж, 89 ширхэг үнэмлэхэд хаягийн хөдөлгөөний бичилт хийлээ. Түүнчлэн үйлчилгээний зааланд нийт 2700 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг хүлээн авч, визийн зөвшөөрөл, хувийн урилга олгох үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх програм хангамжийн хүрээнд 27 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага бүртгүүлж, 10 аж ахуйн нэгж, байгууллагын 14 гадаадын иргэний визийн зөвшөөрлийн хүсэлтийг холбогдох хууль, журмын дагуу хянан шийдвэрлэлээ.

2018 оны 09 дүгээр сарын тоон үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад визийн зөвшөөрөл олголт 22.4, виз олголт 0.6 хувиар, оршин суух зөвшөөрөл олголт 4.0 хувиар, оршин суух зөвшөөрөл сунгалт 5.6 хувиар, оршин суух зөвшөөрлийн хасалт 7.3 хувиар, хувийн урилга олголт 33.3 хувиар тус тус буурсан байна.

1.2 Иргэний харьяалал, хүүхэд үрчлэлт, олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын чиглэлээр:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 82 дугаар зарлигаар Монгол Улсын харьяат болсон Оросын Холбооны Улсын 1 иргэний мэдээллийг бүртгэн, мэдээллийн санд орууллаа.

Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 1 иргэний хүсэлт, баримт бичгийг хүлээн авсан. Мөн Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан харьяалалгүй 1 хүний хүсэлтийг хянан холбогдох байгууллагаас санал авч дүгнэлт боловсруулан Монгол Улсын Ерөнхий сайдад танилцуулан Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн барихаар 2018 оны 08 дугаар сарын 31-ний өдөр албан бичгээр Ерөнхийлөгчийн Тамгын газарт, Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан 2 орны 4 гадаадын иргэн, харьяалалгүй 1 хүний баримт бичгийг хянан 2018 оны 08 дугаар сарын 30-ны өдөр, 09 дүгээр сарын 20-ны өдөр албан бичгээр Харьяатын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 4,5 дахь хэсэгт заасны дагуу санал авах ажиллагааг тус тус хийсэн.

Монгол Улсын харьяатаас гарч бусад 6 улсын харьяат болох хүсэлт гаргасан 20 иргэний хүсэлтийг шинээр хүлээн авч холбогдох ажиллагааг эхлүүллээ.

Монгол Улсын харьяатаас гарах хүсэлт гаргасан 4 иргэний баримт бичгийг хянан 2018 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр албан бичгээр холбогдох санал авахаар Улсын бүртгэлийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газарт тус тус хүргүүлсэн.

Мөн Монгол Улсын харьяатаас гарч бусад 5 улсын харьяат болох хүсэлт гаргасан 23 иргэний хүсэлтэд холбогдох байгууллагаас санал авч, дүгнэлт боловсруулан 2018 оны 08 дугаар сарын 27-ны өдөр, Монгол Улсын харьяатаас гарах хүсэлт гаргасан 20 иргэний хүсэлтэд холбогдох байгууллагаас санал авч, дүгнэлт боловсруулан 2018 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр Монгол Улсын Ерөнхий сайдад танилцуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт, Монгол Улсын харьяатаас гарах хүсэлт гаргасан 2 иргэний хүсэлтэд санал авч, дүгнэлт боловсруулан Монгол Улсын Ерөнхий сайдад танилцуулж, 2018 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр албан бичгээр Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн барихаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт тус тус хүргүүлсэн.

Түүнчлэн хоёрдмол харьяалал үүсгэсэн 84 иргэнийг бүртгэж, мэдээллийн санд оруулсан байна.

Тайлант хугацаанд шинээр 2 төрийн бус байгууллагын хүсэлтийг хүлээн авсан ба Мэргэжлийн зөвлөлийн хурлаар 11 төрийн бус байгууллагын салбар төлөөлөгчийн газрын үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлтийг хэлэлцүүлэн шийдвэрлэлээ.

Мөн гадаадын 3 улсын гэр бүлд үрчлүүлсэн 11 хүүхдийн үрчлэлтийн дараах тайланг хүлээн авч мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн.

1.3 Хяналт шалгалт, албадан гаргах ажиллагааны чиглэлээр:

Тайлангийн хугацаанд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.2, 37.1.3, 37.1.6, 37.1.7, 37.1.11, 37.1.12 дахь заалтуудыг тус тус үндэслэн 15 улсын 52 гадаадын иргэнийг байгууллагын даргын 11 удаагийн тушаалаар тус улсаас албадан гаргасан ба мэдээллийг холбогдох газруудад албан бичгээр хүргүүлэх ажлыг зохион байгуулж ажиллалаа.

Мөн Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан үндэслэлээр 1 улсын 1 гадаадын иргэнийг байгууллагын даргын 1 удаагийн тушаалаар Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлсэн байна.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хүн, хуулийн этгээдэд оногдуулсан шийтгэл, Монгол Улсаас албадан гаргасан гадаадын иргэдийн мэдээллийг 2018 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр, 09 дүгээр сарын 24-ний өдөр албан бичгээр тус тус хүргүүлсэн.

Албадан гаргагдсан гадаадын иргэдийн мэдээлэл:

№	Улс	Зүйлчлэл						Нийт
		37.1.2	37.1.3	37.1.6	37.1.7	37.1.11	37.1.12	
1	АНУ	-	1	-	-	-	-	1
2	БНКазУ	1	1	-	-	-	-	2
3	БНСВУ	-	-	-	1	-	1	2
4	БНХАУ	-	2	-	40	-	2	44
5	БНФилУ	1	-	-	-	-	-	1
6	ОХУ	-	-	-	-	1	-	1
7	ХБННигериУ	-	-	1	-	-	-	1
Нийт		2	4	1	41	1	3	52

Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүгчийн 2018 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн захирамжаар Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын 1 иргэнийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Баривчлах төвийн дэргэдэх гадаадын иргэнийг саатуулах байранд саатуулсан.

Тайлант хугацаанд гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.8 дахь заалтын дагуу хяналтын улсын байцаагч 09 дүгээр сарын 06-ны өдөр Монгол-Оросын “Русский лицей” ерөнхий боловсролын сургуульд Монгол Улсад гадаадын иргэнийг урьж ажиллуулахдаа хууль тогтоомжид заасны дагуу оршин суух зөвшөөрөл, хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авч байхыг мэдэгдэж албан шаардлага хүргүүлсэн.

Тайлангийн хугацаанд 8 удаагийн төлөвлөгөөт, 10 удаагийн төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулж, нийт 92 аж ахуйн нэгж, байгууллага, 1751 гадаадын иргэнийг хамруулснаас 217 гадаадын иргэн, 127 аж ахуйн нэгж, байгууллага /483 гадаадын иргэн/, 6 уригч иргэн /6 гадаадын иргэн/-д Зөрчлийн тухай хуулийн дагуу захиргааны шийтгэл оногдуулж, 168,620,000 /нэг зуун жаран найман сая зургаан зуун хорин мянга/ төгрөгийг улсын төсөвт төвлөрүүллээ.

## ХОЁР. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

### 2.1 Тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн, дотоод ажлын чиглэлээр:

Хууль зүй, дотоод хэргийн сайдтай байгууллагын даргын байгуулсан 2018 оны үр дүнгийн гэрээний 2018 оны 08 дугаар сарын хэрэгжилтийн явцыг 08 дугаар сарын 31-ний өдөр Хууль зүй дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн А.Эрдэнэбулганд цахим хаягаар, Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Цогоод 2018 оны 08 дугаар сарын 31-ний өдөр албан бичгээр, байгууллагын 2018 оны 08 дугаар сарын үйл ажиллагааны тайланг Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Э.Энхтуяад 2018 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр албан бичгээр, байгууллагын 2018 оны 08 дугаар сарын байдлаарх үйл ажиллагааны тоон мэдээг инфографик хэлбэрээр гарган Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Билгүүнд 2018 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр албан бичгээр тус тус хүргүүлж ажиллалаа.

Байгууллагын төв болон орон нутаг дахь газарт нийт 49 өргөдөл ирснийг хүлээн авч, бүртгэлжүүлэн харьяалах газар, хэлтэст нь шилжүүлснээс 34 өргөдөл шийдвэрлэгдэж, 15 өргөдөл хуульд заасан хугацааны хүрээнд шийдвэрлэлтийн шатандаа байгаа ба хугацаа хэтэрсэн өргөдөл байхгүй байна.

Монголын үндэсний олон нийтийн радио телевизээр цацагдах “Бүх нийтийн эрх зүйн боловсролд” шууд нэвтрүүлэг, “Эрх зүйн хөтөч нэвтрүүлэгт оролцох сэдвийг 2018 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр нэгтгэн хүргүүлэв. Тус ажлын хүрээнд 2018 оны 09 дүгээр сарын 07-оос 09-ний өдрүүдэд Хойд бүс дэх газрын Алтанбулаг авто замын боомт, Сүхбаатар төмөр замын боомтод томилолтоор ажиллаж дээрх нэвтрүүлгүүдэд ашиглагдах дүрс бичлэг, эх сурвалжийн яриа зэргийг бэлтгэв. Мөн Дархан-Уул аймаг дахь тоосгоны үйлдвэрт ажиллан, хяналт шалгалтын явцыг харуулсан нарийвчилсан зурагт авалтуудыг хийж, гэрэл зураг, дүрс бичлэгийг архивлалаа.

Архив, албан хэрэг хөтлөлтөд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөрийн 4 дэх шатны зорилтын хүрээнд 2001-2017 оны байнга хадгалах баримтаас даргын тушаал, хурлын тэмдэглэлийн нийт 101 баримтыг цахим хэлбэрт шилжүүлээд байна. Байгууллагын даргын 2017 оны А/37 дугаар тушаалын дагуу цаасан суурьтай баримтыг тоон хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд цахимжуулах 2017 оны түр хадгалах 1072 хадгаламжийн нэгжээс 201 хадгаламжийн нэгж бүхий 45000 хуудас баримтыг сканерт оруулж, эрдэм шинжилгээ, техник боловсруулалт хийсэн.

2018 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр “Бичиг баримтын нууцлал, аюулгүй байдал”-ын талаар сургалтыг Бээжинд суугаа Нидерландын ерөнхий консулын газрын цагаачлалын ажлын албаны мэргэжилтэн Мишээл Верпланке төв болон Буянт-ухаа дахь газрын нийт 21 албан хаагчдад сургалт зохион байгууллаа. Мөн 2018 оны сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан Гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх ажлын хүрээнд 2018 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр Нийслэлийн Цагдаагийн газраас “Гэр бүлийн тухай хууль тогтоомж, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг зохион байгуулж, төвийн 45 албан хаагчид хамрагдав. Мөн байгууллагын даргын 2018 оны А/288 дугаар тушаалын дагуу шинээр томилогдсон албан хаагчдад байгууллагын үндсэн чиг үүрэг, холбогдох хууль тогтоомж, төрийн албан хаагчийн эрх үүрэг, ёс зүйн талаарх мэдлэг олгох онол дадлага хослуулсан анхан шатны сургалтыг 09 дүгээр сарын 10-аас 14-ний өдрүүдэд зохион байгууллаа. Сургалтад төв болон орон нутаг дахь газар, хэлтсийн нийт 13 албан хаагч ажлын 5 хоногийн хугацаанд 44 цагийн танхимын болон дадлагын хичээлд хамрагдсан.

## 2.2 Хууль, эрх зүй, гадаад харилцааны чиглэлээр:

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас боловсруулан ирүүлсэн “Шинжлэх ухаан, технологийн тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгах саналыг 2018 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Билгүүнд хүргүүлэв.

Тайлангийн хугацаанд тус байгууллагын бүтцийн нэгжид шинээр томилогдохоор нэр дэвшсэн 2, шилжин ажиллахаар нэр дэвшсэн 2, дэвшин томилогдохоор нэр дэвшсэн 2, нийт 6 албан тушаалтны хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хянуулахаар хүргүүллээ. Мөн шинээр томилогдсон 2 албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд хүлээн авч баталгаажуулсан байна.

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Нийгмийг Аюулаас Хамгаалах Тэнхимийн Хилээр орох гарах асуудал хариуцсан товчооны дэд дарга Баян-Эрдэнэ тэргүүтэй төлөөлөгчдийг 09 дүгээр сарын 22-оос 25-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо хүлээн авч, байгууллагын үйл ажиллагаатай танилцуулах айлчлалыг зохион байгууллаа.

Мөн 09 дүгээр сарын 10-ны өдөр тус байгууллагын Виз, зөвшөөрлийн газрын дарга, Эрх зүй, гадаад харилцааны хэлтсийн мэргэжилтэн нар Бүгд Найрамдах Франц Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны Тэргүүн зөвлөх, Консул Никола Лакот болон Соёл, хамтын ажиллагаа хариуцсан ажилтан Т.Төрням нарыг байгууллагадаа хүлээн авч уулзсан.

### 2.3 Мэдээллийн технологийн чиглэлээр:

Дорноговь аймаг дахь газрын Сайншанд сумын төлөөллийг байгууллагын нэгдсэн сүлжээнд холбох ажлын хүрээнд Мэдээлэл холбооны сүлжээ ТӨК-д албан бичиг хүргүүлэн холболтын ажлыг хийж, сүлжээг ажиллагаанд орууллаа.

### 2.4 Дүн шинжилгээ, дотоод аудит, зөвлөгөө мэдээллийн чиглэлээр:

Гадаадын иргэн, харьяатын газраас 2018 оны эхний хагас жилд хэрэгжүүлсэн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийг 2018 оны эхний хагас жилд хөгжүүлэх үндсэн чиглэл, Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэр, Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан тушаал, шийдвэр болон тус байгууллагаас 2018 оны эхний хагас жилд дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлсэн байдлыг хамруулан үр дүнг үнэлж, шинэлэг, ололттой болон хэрэгжилт хангалтгүй арга хэмжээний талаар хяналт-шинжилгээ, үнэлгээ, түүнчлэн Засгийн газрын 2018 оны 145 дугаар тогтоолоор баталсан “Монголын Улсын виз олгох журам”, 146 дугаар тогтоолоор баталсан “Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам”-ыг шинэчлэн найруулсантай холбогдуулан байгууллагын үйлчилгээний чанар, хүртээмж, албан хаагчдын ёс зүй, харилцааны талаар иргэдээс санал асуулгыг анкетын аргаар байгууллагын үйлчилгээний төв заал, Буянт-Ухаа боомт, Замын-Үүдийн авто замын боомт, Гашуун сухайт болон Шивээхүрэн боомтоор үйлчлүүлсэн нийт 83 иргэнээс авч, санал асуулгыг нэгтэн, дүн шинжилгээ хийсэн.

Мөн “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоолын 1.3. “төрийн албан хаагчдын ажлын байрны шинжилгээ хийж, шинжилгээний дүнд тулгуурлан байгууллагын чиг үүргийн давхардал, хийдлийг арилгаж, ажлын бүтээмж, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах” чиглэлийн дагуу байгууллагын даргын баталсан 91 ажлын байрны тодорхойлолтод давхардал, хийдлийг арилгах зорилгоор ажлын байрны шинжилгээг хийж гүйцэтгэлээ.

Байгууллагын даргын баталсан удирдамжийн дагуу Өмнөд бүс дэх газарт 2018 оны 09 дүгээр сард 2017, 2018 оны санхүүгийн тайлан болон архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр шалгалтыг зохион байгуулж, шалгалтын явцад алдаа, дутагдал анхаарах асуудлын талаар зөвлөгөө, мэдээлэл өгөн төсөв, санхүүгийн дотоод аудитын чиглэлээр 8 төрлийн сорилыг хийж гүйцэтгэн ажиллалаа.

Тайлант хугацаанд нийт 3137 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгснөөс 1800-1882 дугаарын утсаар нийт 1824, биечлэн 1313 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгсөн байна. Үүнээс виз, визийн зөвшөөрлийн талаар утсаар 747, биечлэн 446, Монгол улсад албан болон хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл олгох, сунгах, хасах

талаар утсаар 511, биечлэн 708, бусад асуудлаар утсаар 566, биечлэн 159 иргэнд тус тус зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа.

#### 2.5 Санхүү, хөрөнгө оруулалт, хангамжийн ажлын талаар:

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын багцад Монгол Улсын Төсвийн тухай хуулийн дагуу 2018 оны төсөв 6,4 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд өссөн дүнгээр 09 дүгээр сарын байдлаар нийт 4,9 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдож зохих дүрэм, журмын дагуу анхан шатны баримтыг үндэслэн зарцууллаа.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Засгийн газрын 2003 оны 172 дугаар тогтоолын дагуу 2018 оны 09 дүгээр сарын байдлаар өссөн дүнгээр 2,5 тэрбум төгрөгийн тэмдэгтийн хураамжийн орлого, 310 сая төгрөгийн хүү торгуулийн орлого, 135 сая төгрөгийн визний хуудасны орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлээд байна.

#### 2.6 Боомт, орон нутгийн чиглэлээр:

Монгол Улсаас хилийн чанадад суугаа Элчин сайдын яам, Дипломат төлөөлөгчийн газар, Консулын газар, Өргөмжит консулаас визийн хүчинтэй хугацаа буруу, нэрийн үсэг дутуу, визийн зориулалт бичигдээгүй нийт 34 орны 230 иргэнд олгогдсон визийг тухай бүр хуулбарлан авч, Засгийн газрын 2018 оны 145 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын виз олгох журамд заасны дагуу шинээр виз олгон хил нэвтрүүлсэн болно.

Монгол Улсад орох визгүй болон ирсэн зорилгодоо нийцсэн зохих ангиллын визгүй нийт гадаадын 41 иргэнийг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйл, Засгийн газрын 2010 оны 338 дугаар тогтоолд заасны дагуу тус тус орох чиглэлд хил нэвтрүүлэлгүй буцаасан ба гарах-орох визгүй, виз авах байгууллагын албан хүсэлтгүй, оршин суух зөвшөөрөлд хасалт хийлгэх албан бичиггүй зэрэг үндэслэлээр гадаадын 20 иргэнийг гарах чиглэлд хил нэвтрүүлэлгүй буцаасан. Мөн Монгол Улсад визгүй зорчигч гадаадын иргэн, хөдөлмөр эрхлэх магадлалтай 8 орны 202 иргэнтэй ярилцлага хийж баримт бичгийг хуулбарлан хилээр гарсан байдалд хяналт тавьж бүртгэл хөтөллөө.

Монгол Улсын хилийн тухай хуулийн 17.4 дэх хэсэгт “Хилийн хяналтын байгууллагын хяналт шалгалтаар илрүүлсэн гадаадын иргэний виз, бүртгэлийн зөрчлийг гадаадын иргэн, харьяатын байгууллага шийдвэрлэнэ” гэж заасны дагуу хилийн шалган нэвтрүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж буй албан хаагчид виз, бүртгэлийн зөрчилтэй гадаадын иргэдийг тус байгууллагад шилжүүлж, зөрчлийг шийдвэрлүүлэхгүйгээр улсын хил нэвтрүүлсэн гадаад иргэдийн талаар Хууль зүй, дотоод хэргийн яам болон Хил хамгаалах ерөнхий газарт тус тус албан бичгээр мэдэгдэж ажиллалаа.

## ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР